



**УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТГИЙН АНГИЛЛЫГ
ӨӨРЧЛӨХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТОГТООЛЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг. Тогтоолын төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 6.1.4-т “Цэнгэг усны нөөц, урсац бүрэлдэх эх, ойн сан бүхий газар, биологийн олон янз байдлын хувьд чухал газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах судалгаа хийж өргөжүүлэх замаар онцлог экосистемийн үйлчилгээ, үнэ цэнийг нэмэгдүүлнэ” гэж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 6.1.1-т “Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөн нийт газар нутгийн 27 хувьд хүргэж, цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 55 хувийг улсын тусгай хамгаалалтад авна” гэж, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 5.1.6-д “Цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 55 хувийг улсын тусгай хамгаалалтад авна” гэж тус тус заасан.

2. Сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлт, хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс байгаль орчин доройтох, байгалийн нөөц хомсдох үйл явц эрчимжиж байна. Тухайлбал, тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх судалгааны ажлын тайлангаас үзэхэд манай орны нийт нутаг дэвсгэрийн 70 гаруй хувь нь ямар нэгэн хэмжээгээр цөлжилтөд өртөж, нийт бэлчээрийн 70 орчим хувь талхлагдаж, 300 гаруй зүйлийн амьтан, ургамал устах аюулд орж, олон арван гол, горхи, булаг, шанд, нуур, цөөрөм ширгээд байна.

Иймд байгалийн унаган төрх, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх, хамгаалах, ногоон хөгжлийн түшиц газрыг бий болгоход экологийн эрх ашгийг тэргүүн зэрэгт тавьсан менежмент бүхий тогтолцоог бэхжүүлэн хамгаалах, түүндээ зохицсон уламжлалт аж ахуйгаа хүн төрөлхтний соёл иргэншлийн нийтлэг ололтоор баяжуулан хөгжүүлэх үүднээс Монгол Улсын зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад хамруулах шаардлагатай байна.

Улсын тусгай хамгаалалтад хамруулахаар төлөвлөж буй газар нутгийг байгалийн бүс, бүслүүрийн үндсэн хэв шинжийг төлөөлж чадах, экосистемийн онцлог,

байгалийн унаган төрхийг хадгалж үлдсэн зэрэг үндсэн шалгуур үзүүлэлтийг харгалзан үзэхээс гадна холбогдох аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санал, эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэн, судлаачдын судалгааны ажлын үр дүн, иргэдийн санал, дүгнэлтэд үндэслэн, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Засгийн газрын өргөн мэдүүлснээр газар нутгийг тусгай хамгаалалтад авах тухай шийдвэр гаргах, эдгээр газрыг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тодорхой ангилалд хамруулах, дархан цаазат болон байгалийн цогцолборт газрын хилийн заагийг батлах, өөрчлөх” гэж заасны дагуу Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулах шаардлагатай байна.

Хоёр.Тогтоолын төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Архангай аймгийн Эрдэнэбулган сумын нутагт орших Булган уулын улсын тусгай хамгаалалттай газрын байгалийн дурсгалт газрын ангиллыг ангилал дээшлүүлэн дархан цаазат газрын ангилалд хамруулснаар байгалийн унаган төрх, өвөрмөц тогтоц, үндэсний хэмжээнд төдийгүй дэлхийн хэмжээнд устах аюулд орсон болон устах аюулд орж болзошгүй олон зүйлийн амьтан, ургамлын үндсэн тархац нутаг, тэдгээрийн амьдрах орчныг хамгаалах, байгалийг унаган төрхөөр нь хойч үедээ өвлүүлэн үлдээх, ногоон эдийн засгийн хөгжлийн түшиц газрыг бүрдүүлэх бөгөөд улсын тусгай хамгаалалттай газар нутгийн талбайн хэмжээ 2,000.1 га-аар нэмэгдэнэ.

Энэхүү зорилтын хүрээнд Архангай аймгийн Эрдэнэбулган сумын нутагт орших Булган уулын улсын тусгай хамгаалалттай газрын байгалийн дурсгалт газрын ангиллыг дархан цаазат газрын ангилалд хамруулах, талбайн хэмжээг нэмэгдүүлж байгаа дархан цаазат газрын хилийн заагийг тогтоолын хавсралтаар батлахаар тогтоолын төсөлд тус тус тусгана.

Түүнчлэн, тогтоолын төсөлтэй холбогдуулан “Улсын тусгай хамгаалалттай газрын ангиллыг шинэчлэн тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 1995 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн 26 дугаар тогтоолын 4 дэх заалтын 1 дэх дэд заалтыг хүчингүй болгох зохицуулалтыг тогтоолын төсөлд тусгана.

Гурав.Тогтоолын төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авах арга хэмжээний санал

Экосистемийн хувьд тогтвортой байдлыг хадгалах болон байгалийн аялал жуулчлал хөгжүүлэхэд ач холбогдол бүхий Архангай аймгийн Эрдэнэбулган сумын нутагт орших Булган уулын улсын тусгай хамгаалалттай газрын байгалийн дурсгалт газрын ангиллыг дархан цаазат газрын ангилал болгон улсын тусгай хамгаалалтад хамруулснаар биологийн олон янз байдал тэр дундаа Баданги, Хүдэр, Халиу буга нэн ховор, ховор амьтан, ургамлыг хамгаалах, хангайн нуруунд янгир ямааг нутагшуулах, байгаль экологийн тэнцвэрт байдлыг хангах, байгаль, түүх, соёл, шинжлэх ухааны давтагдашгүй их өвийг ирээдүй хойч үедээ дамжуулан үлдээх, орчны доройтлыг хязгаарлан зогсоох, олон улсын төсөл, хөтөлбөрийн хүрээнд тусгай хамгаалалттай газар нутаг болон түүний орчны бүсийн хүн ардын аж амьдралыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, тэднийг хамгааллын менежментийн үйл ажиллагаанд татан

оролцуулах, горим, дэглэмийг сахин хамгаалах замаар бус нутгийн тогтвортой хөгжлийг хангахад эерэг нөлөө үзүүлнэ.

Түүнчлэн байгалийн унаган төрх, өвөрмөц тогтоц, ховор, нэн ховор амьтан, ургамлын амьдрах орчныг хамгаалах, судалгаа шинжилгээний түшиц газар болгох, байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, байгалийг унаган төрхөөр нь хадгалж үлдээхэд тогтоолын төслийн ач холбогдол оршино.

Тогтоолын төсөл батлагдсанаар тэдгээрийн хамгаалалтын менежментийг Хангайн нурууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаанд хариуцуулна.

Дөрөв.Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай уялдсан байдал, уг хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал

Тогтоолын төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон бусад хууль тогтоомжтой нийцэх бөгөөд тогтоолын төсөлтэй холбогдуулан “Улсын тусгай хамгаалалттай газрын ангиллыг шинэчлэн тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын 1995 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн 26 дугаар тогтоолын 4 дэх заалтын 1 дэх дэд заалтыг хүчингүй болсонд тооцохоор тусгана.

---o0o---